



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 сарын 17 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Статистикийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “нууцын тухай” гэсний дараа “болон хүний хувийн мэдээлэл хамгаалах” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Статистикийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь заалтын “мэдээллийн нууцыг” гэснийг “эмзэг мэдээллийг” гэж, 22 дугаар зүйлийн гарчгийн “нууцыг” гэснийг “нууц, хүний эмзэг мэдээллийг” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нууцад” гэснийг “төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд” гэж, мөн зүйлийн 6 дахь хэсгийн “хувь хүн, хуулийн этгээдийн мэдээллийн нууцыг чанд” гэснийг “байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР